



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/223/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улиастай сум

2024 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын

тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: [Bat-Undraa@audit.gov.mn](mailto:Bat-Undraa@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: [Boldbaatarakh@audit.gov.mn](mailto:Boldbaatarakh@audit.gov.mn)

Ахлах аудитор: Ц.Оюунсүвд

Утас: 99076038

Цахим хаяг: [oyunsuvdts@audit.gov.mn](mailto:oyunsuvdts@audit.gov.mn)

Гэрээт аудитор : Ц.Алтантуул

Утас: 91195554

Цахим хаяг: [tuul9565@gmail.com](mailto:tuul9565@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. Аудитын илрүүлэлт .....	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	16

---

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Уластай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12  
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2024.02.23 № 107  
таныг \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН ХОЁРДУГААР  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Н.ӨСӨХБАЯР-Д

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь төсвийн санхүүжилтээр 2,877.4 сая төгрөгийн, орон нутгийн санхүүжилтээр 414.8 сая төгрөгийн, нэмэлт санхүүжилтээр 12.0 сая төгрөгийн, нийт 3,304.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн, зарцуулсан байна. Тайлант оны мөнгөн гүйлгээний нийт зардал 3,015.1 сая төгрөг бөгөөд 105.1 сая төгрөгөөр хөрөнгө худалдан авсан байна.

**Аудитын гол асуудал**

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан тодруулгуудад дүгнэлт өгөх аудитаар тушаалгүйгээр нэмэгдэл цалин олгосон алдаа зөрчил илэрсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн үндсэн хөрөнгийн бүртгэлд ажиглалт хийхэд хөрөнгийн тооллогыг журмын дагуу хийж гүйцэтгэдэггүй алдаа зөрчил илэрсэн байна.

013020172

Audit(D)Дүгнэлт/2024

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР  Д.БАТ-УНДРАА



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>323,602,084.99</u></b>	<b><u>501,910,923.52</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	231,140,025.92	224,954,667.92
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	410,900.00	440,400.00
35130	Эм боох материал	410,900.00	440,400.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	230,729,125.92	224,514,267.92
35410	Бичиг хэргийн материал	4,991,200.00	4,750,200.00
35440	Түлш шатах тослох материал	6,050,000.00	5,770,000.00
35450	Барилгын засварын материал	1,591,000.00	1,591,000.00
35460	Хүнсний материал	8,161,370.00	1,779,390.00
35470	Бусад хангамжийн материал	209,935,555.92	210,623,677.92
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>4,651,372,790.40</u></b>	<b><u>4,565,843,838.70</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	4,651,372,790.40	4,565,843,838.70
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	4,425,075,290.40	4,339,936,338.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,479,295,245.00	4,479,295,245.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-380,969,547.34	-512,151,286.66
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	363,052,841.93	430,753,550.41
39206	Хуримтлагдсан элэгдэл	-237,239,596.77	-250,622,939.12
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	255,151,098.45	267,569,229.45
39208	Хуримтлагдсан элэгдэл	-136,666,865.25	-155,388,272.38
39214	Бусад үндсэн хөрөнгө	50,382,840.00	50,382,840.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-37,516,227.98	-41,144,511.86
39217	Ном	69,585,502.36	71,242,483.86
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	226,297,500.00	225,907,500.00
39301	Програм хангамж	2,832,000.00	2,832,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,732,000.00	-2,122,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	225,197,500.00	225,197,500.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>4,974,974,875.39</u></b>	<b><u>5,067,754,762.22</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>4,974,974,875.39</u></b>	<b><u>5,067,754,762.22</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	4,974,974,875.39	5,067,754,762.22
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	616,475,838.51	616,475,838.51
51101	Өмч: - төрийн	616,475,838.51	616,475,838.51
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	3,483,467,564.87	3,576,247,451.70
51210	Өмнөх үеийн үр дүн	3,483,467,564.87	3,483,467,564.87
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	92,779,886.83
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	875,031,472.01	875,031,472.01
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>4,974,974,875.39</u></b>	<b><u>5,067,754,762.22</u></b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,686,954,188.03</b>	<b>3,337,311,139.98</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,261,838,088.03</b>	<b>44,606,839.98</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	89,019,688.03	44,606,839.98
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	89,019,688.03	12,015,400.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	89,019,688.03	32,591,439.98
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>425,116,100</b>	<b>3,292,704,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	00.00	2,877,841,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	2,877,841,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	6,644,700.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	6,644,700.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	418,471,400.00	414,862,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	418,471,400.00	414,862,700.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,605,368,537.58</b>	<b>3,244,531,253.15</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,605,368,537.58</b>	<b>3,244,531,253.15</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,377,799,917.58	3,032,599,805.40
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,507,715,391.74	1,973,352,109.00
210101	Үндсэн цалин	1,062,305,700.74	1,272,886,821.00
210102	Нэмэгдэл	342,730,723.00	567,196,729.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	00.00
210104	Урамшуулал	102,678,968.00	133,268,559.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	188,533,872.00	256,591,314.47
210201	Тэтгэврийн даатгал	129,845,606.91	177,276,347.51
210202	Тэтгэмжийн даатгал	14,749,568.76	20,046,827.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,742,695.06	15,879,061.84
210204	Ажилгүйдлийн даатгал	2,925,811.29	3,944,451.94
210205	Эрүүл мэндийн даатгал	29,270,189.98	39,444,625.75
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	324,137,861.00	392,861,650.25
210301	Гэрэл, цахилгаан	17,992,658.00	19,471,470.25
210302	Түлш, халаалт	304,968,003.00	345,093,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,177,200.00	28,296,780.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	00.00	59,309,361.00
210401	Бичиг хэрэг	00.00	28,956,131.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	8,582,860.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	21,770,370.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	70,259,545.00	76,071,280.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	540,950.00	410,900.00
210502	Хоол, хүнс	69,718,595.00	75,660,380.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	11,555,750.00	4,500,000.00
210604	Урсгал засвар	11,555,750.00	4,500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	23,895,200.00	20,824,891.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,635,700.00	6,646,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,259,500.00	14,718,491.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>251,702,297.84</b>	<b>249,089,199.68</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,582,024.00	27,790,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,214,570.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	190,905,703.84	221,298,599.68
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>227,568,620.00</b>	<b>211,931,447.75</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>182,434,800.00</b>	<b>194,430,398.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	148,778,800.00	150,223,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,656,000.00	44,206,898.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>45,133,820.00</b>	<b>17,501,049.75</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	45,133,820.00	17,501,049.75
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>81,585,650.45</b>	<b>92,779,886.83</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>81,585,650.45</b>	<b>92,779,886.83</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,597,934,500.00</b>	<b>3,304,719,700.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,172,818,400.00</b>	<b>12,015,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,172,818,400.00</b>	<b>2,877,841,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,172,818,400.00	2,877,841,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>6,644,700.00</b>	<b>00.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	6,644,700.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>418,471,400.00</b>	<b>414,862,700.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	418,471,400.00	414,862,700.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,435,825,440.93</b>	<b>3,015,119,223.47</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,435,825,440.93</b>	<b>3,015,119,223.47</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,208,256,820.93</b>	<b>2,803,187,775.72</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,507,850,173.93</b>	<b>1,973,352,109.00</b>
210101	Үндсэн цалин	1,062,440,482.93	1,272,886,821.00
210102	Нэмэгдэл	342,730,723.00	567,196,729.00
210104	Урамшуулал	102,678,968.00	133,268,559.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>188,533,872.00</b>	<b>256,591,314.47</b>
210201	Тэтгэврийн даатгал	129,845,606.91	177,276,347.51
210202	Тэтгэмжийн даатгал	14,749,568.76	20,046,827.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,742,695.06	15,879,061.84
210204	Ажилгүйдлийн даатгал	2,925,811.29	3,944,451.94
210205	Эрүүл мэндийн даатгал	29,270,189.98	39,444,625.75
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>318,037,861.00</b>	<b>392,861,650.25</b>

210301	Гэрэл, цахилгаан	13,192,658.00	19,471,470.25
210302	Түлш, халаалт	303,668,003.00	345,091,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,177,200.00	28,296,780.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>28,249,901.64</b>	<b>52,081,528.00</b>
210401	Бичиг хэрэг	5,520,850.00	15,327,510.00
210402	Тээвэр, шатахуун	7,166,155.00	6,647,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,345,936.64	9,591,938.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,187,000.00	4,091,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,029,960.00	16,423,280.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>71,396,870.00</b>	<b>69,278,400.00</b>
210502	Хоол, хүнс	71,396,870.00	69,278,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>12,471,900.00</b>	<b>4,500,000.00</b>
210604	Урсгал засвар	12,471,900.00	4,500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>23,895,200.00</b>	<b>20,824,891.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,635,700.00	6,646,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,259,500.00	14,178,491.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>86,070,944.00</b>	<b>85,779,411.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	59,181,774.00	60,275,480.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,889,170.00	25,503,931.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>227,568,620.00</b>	<b>211,931,447.75</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>182,434,800.00</b>	<b>194,430,398.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	148,778,800.00	150,223,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,656,000.00	44,206,898.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>45,133,820.00</b>	<b>17,501,049.75</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	45,133,820.00	17,501,049.75
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>162,109,059.07</b>	<b>289,600,476.53</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>69,647,000.00</b>	<b>105,106,280.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>69,647,000.00</b>	<b>105,106,280.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>69,647,000.00</b>	<b>105,106,280.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	69,647,000.00	105,106,280.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-69,647,000.00</b>	<b>-105,106,280.00</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	616,475,838.51	875,031,472.01	3,483,467,564.87	4,974,974,875.39

D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	616,475,838.51	875,031,472.01	3,483,467,564.87	4,974,974,875.39
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	616,475,838.51	875,031,472.01	3,483,467,564.87	4,974,974,875.39
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	92,779,886.83	92,779,886.83
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	616,475,838.51	875,031,472.01	3,576,247,451.70	5,067,754,762.22

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,985,815,600.00	2,705,362,803.47
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,985,815,600.00	2,705,362,803.47
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,758,270,500.00	2,510,932,405.47
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,192,294,900.00	1,966,546,023.47
210101	Үндсэн цалин	1,461,496,800.00	1,266,080,735.47
210102	Нэмэгдэл	590,219,600.00	567,196,729.00
210104	Урамшуулал	140,578,500.00	133,268,559.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	274,036,400.00	263,397,400.00
210201	Тэтгэврийн даатгал	186,344,700.00	179,110,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	21,922,900.00	21,071,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,358,300.00	16,857,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,384,600.00	4,214,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	43,845,900.00	42,143,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	69,278,400.00	69,278,400.00
210502	Хоол, хүнс	69,278,400.00	69,278,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	27,149,000.00	22,364,891.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,146,400.00	6,646,400
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,002,600.00	15,718,491.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	195,511,800.00	189,345,691.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	170,007,800.00	163,841,760.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,504,000.00	25,503,931.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	227,545,100.00	194,430,398.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	227,545,100.00	194,430,398.00
213205	Төрөөс иргэдэд олгох дэмжлэг	183,338,200.00	150,223,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	44,206,900.00	44,206,898.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,975,669,200.00	2,889,857,000.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	2,970,300,200.00	2,883,210,600.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,970,300,200.00	2,883,210,600.00

<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	92.00	106.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	79.00	93.00
620003	Үйлчлэх ажилтан	12.00	12.00

## 2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>397,361,650.25</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>397,361,650.25</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	397,361,650.25
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	392,861,650.25
210301	Гэрэл, цахилгаан	19,471,470.25
210302	Түлш, халаалт	345,093,400.00
210303	Цэвэр, бохир ус	28,296,780.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,500,000.00
210604	Урсгал засвар	4,500,000.00

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь Хүүхэд нэг бүрийн суралцаж хөгжихөд нь тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад нь бүх талын хамтын оролцоог хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах

**Эрхэм зорилго:** Экосистемийн тэнцвэрт байдлыг хангахуйц байгалийн нөөц, баялагийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх цогц бодлогыг хэрэгжүүлж, хөгжлийн тогтвортой орчинг бий болгох, түүнд түшиглэсэн аялал жуулчлалын цогц бодлого хэрэгжүүлэх, жам ёсоор нөхөн сэргээх боломжийг бүрдүүлэх зорилго тавин ажиллаж байна.

Боловсролын салбарын төсвийн шинэчлэл хийгдсэн ба тус сургууль нь 2023 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 10 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөж ажилласан бөгөөд 97.2-иар хэрэгжсэн байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

**Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын зөвлөл нь 2023 оны ажлын төлөвлөгөөндөө 8 ажил хийхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт бүрд удирдамж батлуулж, хяналтаар илэрсэн зөрчлийг арилгаж ажилласан байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 92,779.9 мянган төгрөг буюу 1.8 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	231,140.10	224,954.70	(6,185.40)
Үндсэн хөрөнгө	4,651,372.90	4,565,843.80	(85,529.10)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,974,974.80</b>	<b>5,067,754.70</b>	<b>92,779.90</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,974,974.80	5,067,754.70	92,779.90
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>4,974,974.80</b>	<b>5,067,754.70</b>	<b>92,779.90</b>

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

#### Тайланд онд:

Бараа материалын эхний үлдэгдэл 231,140.1 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа материал 281,990.7 мянган төгрөг, үнэ төлбөргүйгээр 1,928.0 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, зарцуулсан 290,104.1 мянган төгрөгийн бараа материал хасагдаж, эцсийн үлдэгдэл 224,954.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 6,185.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 105,106.2 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй 30,663.3 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч, 53,993.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө актласан байна. Жилийн эцэст 4,565,843.8 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 221,298.5 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 92,779.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

### 5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,970,300.2 мянган төгрөг, нийт зарлагыг 2,970,300.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,970,300.2 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,889,857.0 мянган төгрөг буюу 95,9 хувийн гүйцэтгэлтэй бөгөөд 17,501.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>Улсын төсвөөс санхүүжих</b>					
<b>71801</b>	<b>Сургуулийн өмнөх боловсрол</b>				
81605	Эрүүл мэндийг дэмжих	9,470.50	6,801.10		<b>72%</b>
81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	88,205.00	88,205.00		<b>100%</b>
81823	Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	15,302.40	13,132.00		<b>86%</b>
81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2,152,838.70	2,008,067.40		<b>93.3%</b>
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	339,387.20	313,830.90		<b>92.5%</b>
<b>НИЙТ</b>		<b>2,970,300.2</b>	<b>2,889,857.0</b>		<b>95.9%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3. Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 1 хөтөлбөрийн хүрээнд 1 арга хэмжээг санхүүжүүлж, тогтмол зардалд 397,361.6 мянган төгрөг зарцуулсан байна.

### 4. Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

### 5. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

/Мянган төгрөг/

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Харьцуулалтын арга	Хүүхдийн хоол – Мах	84,500.00	82,646.80
2	Харьцуулалтын арга	Хүүхдийн хоол – Хүнсний ногоо	30,000.00	28,595.50

3	Харьцуулалтын арга	Хүүхдийн хоол – Сүү, цагаан идээ	6,000.00	4,500.00
4	Харьцуулалтын арга	Хүүхдийн хоол – бусад хүнсний материал	114,300.00	109,515.20
5	Харьцуулалтын арга	Хүүхдийн хоол – Талх, нарийн боов	28,950.00	27,359.10
6	Шууд гэрээ байгуулах	Түлш халаалт	345,093.40	345,093.40
7	Шууд гэрээ байгуулах	Гэрэл цахилгаан	35,958.40	19,471.50
8	Шууд гэрээ байгуулах	Цэвэр, бохир ус	29,310.90	28,296.80
9	Шууд худалдан авалт	Урсгал засвар	4,500.00	4,500.00
10	Шууд худалдан авалт	Харилцаа холбооны зардал	17,002.60	15,718.50
11	Шууд худалдан авалт	Эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ	9,470.50	6,801.10
13	Шууд худалдан авалт	Сургалтыг дэмжих бусад үйлчилгээ	15,302.40	13,132.00
<b>ДҮН</b>			<b>720,388.20</b>	<b>685,629.90</b>

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

#### 4. АУДИТЫН ТАЙЛАН

##### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Ари финайнс аудит” ХХК-ийн гэрээт аудитор Ц.Алтантуул гүйцэтгэж, хяналтыг “Ари финайнс аудит” ХХК-ийн захирал Д.Ариунаа анхан шатанд хянаж, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитын менежер Х.Болдбаатар нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа дараагийн шатанд хяналтыг хэрэгжүүлсэн.

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Ари финайнс аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

##### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 987,958.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 14,819.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 11,114.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 29 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 заалт зөвлөмж, 6,602.4 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг биелүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	6,602.4	1	6,602.4	100
Зөвлөмж	3		3		100
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>6,602.4</b>	<b>4</b>	<b>6,602.4</b>	<b>100</b>

##### Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар сургуулийн спорт заалны түрээсийн орлогыг анхаарах шаардлагатай байна.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 201,026 төгрөгийн зөрчил илэрч төлбөрийн акт тогтоолоо.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 201.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 10,913.8 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

Ур чадварын нэмэгдэл тушаалгүй олгосон 201,026 төгрөгт төлбөрийн акт тогтоолоо.

### 5.2 Албан шаардлага хүргүүлээгүй

### 5.3 Зөвлөмж өгөгдөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Ур чадвар тушаалгүй олгосон	1	201.0	1	201.0								
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>201.0</b>	<b>1</b>	<b>201.0</b>								

### АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА ОГНОО: 2024-02-22

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.БОЛДБААТАР ОГНОО: 2024-02-22

АХЛАХ АУДИТОР

Ц.ОЮУНСУВД ОГНОО: 2024-02-22

АРИ ФИНАЙНС АУДИТ ХХК-ИЙН

ГЭРЭЭТ АУДИТОР

Ц.АЛТАНТУУЛ ОГНОО: 2024-02-22